

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

“Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай
этгээдийн үйл ажиллагааны журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.16, 63.1.2, Улсын Их Хурлын 2013 оны 41 дүгээр тогтоолын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь: */ Энэ хэсгийн ...тухай хуулийн гэсний дараах 36.16-г Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 сарын 11-ний өдрийн 198-р тогтоолоор нэмсэн/*

1. “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооны “Брокер, дилерийн үйл ажиллагааны тухай журам”-ыг батлах тухай 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 223 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Журмын хэрэгжилтийг хангаж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны зарчим, хориглох зүйл, харилцагчтай гэрээ байгуулах, түүнийг мэдээллээр хангах, захиалга хүлээн авах, биелүүлэх, өөрчлөх, цуцлах, дуусгавар болгох, компанийн өөрийн хөрөнгөөр үнэт цаасны арилжаанд оролцох, үйлчилгээний шимтгэл, харилцагчдад мэдээлэл хүргэх, зар сурталчилгаа явуулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, архивын бичиг баримт хадгалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “зохицуулалттай этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1, 24.1.2, 24.1.3, 24.1.5-д заасан тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээдийг;

1.2.2. “зохицуулалттай этгээдийн мэргэжилтэн” гэж харилцагчтай харилцдаг мэргэжилтэн, удирдах албан тушаалтныг;

1.2.3. “харилцагч” гэж зохицуулалттай этгээдтэй байгуулсан гэрээний хүрээнд үйлчлүүлж буй хөрөнгө оруулагч этгээдийг;

1.2.4. “зах зээлийн захиалга” гэж тухайн үнэт цаас худалдаж авахад хамгийн доод, худалдахад хамгийн дээд ханшаас эхэлж биелэгдэх захиалгыг;

1.2.5. “нөхцөлт захиалга буюу үнийн хязгаарлалттай захиалга” гэж худалдаж авах үнийн дээд түвшин, эсхүл худалдах үнийн доод түвшинг заасан захиалгыг;

1.2.6. “хойшлуулах болзлоор өгсөн захиалга” гэж бий болох эсэх нь мэдэгдэхгүй, эсхүл нэгэнт бий болсныг мэдээгүй байгаа үйл явдлаас шалтгаалан гэрээнд заасан эрх үүрэг нь үүсэхээр брокерийн компанитай тохиролцож өгсөн харилцагчийн захиалгыг;

1.2.7. “зар сурталчилгаа” гэж зохицуулалттай этгээдээс үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, бусад үйлчилгээг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон утас, интернет, цахим шуудан, хэвлэмэл хуудас зэрэг хэлбэрээр санал болгож түгээсэн мэдээллийг;

1.2.8. “брокерийн үйл ажиллагаа” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.1-т заасныг;

1.2.9. “дилерийн үйл ажиллагаа” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 37.1-т заасныг;

1.2.10. “андеррайтерийн үйл ажиллагаа” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.1-т заасныг;

1.2.11. “хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 39.1-т заасныг;

1.2.12. “төлбөр гүйцэтгэгч банк” гэж төлбөр гүйцэтгүүлэгчээс ирүүлсэн даалгаврын дагуу үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөрийг гүйцэтгэх банкийг;

1.2.13. “барьцаа хөрөнгө” гэж харилцагчийн үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөрийг гүйцэтгэх үүргийг баталгаажуулах зорилгоор Төлбөр гүйцэтгэгч банк дахь тусгай дансанд брокер, дилерийн компаниас болон брокерийн компани харилцагчтай тохиролцсоны үндсэн дээр Харилцагчаас байршуулах мөнгөн хөрөнгийг;

1.2.14. “барьцааны данс” гэж барьцаа хөрөнгийг байршуулах зорилго бүхий тусгайлсан дансыг;

1.2.15. “төлбөрийн баталгааны сан” гэж үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, үнэт цаасны зах зээлийн тогтвортой байдлыг хангах, эрсдлийг бууруулах зорилгоор брокер, дилерийн компаниудаас мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлсэн санг;

1.2.16. “төлбөрийн үйл ажиллагаа” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44.1 дэх хэсэгт заасныг ойлгоно.

Хоёр. Зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны зарчим

2.1. Зохицуулалттай этгээд нь дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллана:

2.1.1. хууль тогтоомж, Хороо болон өөрийгөө зохицуулах байгууллагаас баталсан дүрэм, журмыг мөрдөж ажиллах;

2.1.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.7-д зааснаар зохицуулалттай этгээдийн нэр нь оноосон нэр болон “Үнэт цаасны компани” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл “ҮЦК” гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

2.1.3. харилцагчтай нэмэлт нөхцлөөр зуучлалын үйлчилгээний гэрээ байгуулахдаа 3 дугаар маягтын дагуу харилцагчаа таньж, судалсан байх;

2.1.4. хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл, зөвлөгөөгөөр харилцагчийг хангах;

2.1.5. харилцагчийн ашиг сонирхлыг дээгүүр тавьж, албан үүргээ гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;

2.1.6. харилцагчийн хөрөнгийг компанийн хөрөнгөөс тусгаарлан, найдвартай байдлыг хангаж ажиллах;

2.1.7. Хороо, арилжаа эрхлэх байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай боловсон хүчин, санхүү болон техник технологитой байх;

2.1.8. үйл ажиллагаатай холбоотой анхан шатны баримтыг стандартын дагуу хөтөлж, хадгалах;

2.1.9. зохицуулалттай этгээд нь зохицуулалтын үйлчилгээний төлбөрийг цаг тухайд нь барагдуулах;

2.1.10. дотоод хяналтын тогтолцоотой байх.

Гурав. Зохицуулалттай этгээдэд хориглох зүйл

3.1. Зохицуулалттай этгээд нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

3.1.1. үнэт цаасыг нийтэд худалдахаар санал болгох, үнэт цаасны арилжааны явцад харилцагчдад хуурамч мэдээлэл өгөх, төөрөгдүүлэх;

3.1.2. гэрээнд заасны дагуу үнэт цаас худалдан авахтай холбогдуулан брокер нь харилцагчид зээл олгосноос бусад тохиолдолд компанийн болон харилцагчийн данс хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэх;

3.1.3. дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох, харилцагчдад хүргэх мэдээллийг нуун дарагдуулах, өгөхөөс татгалзах;

3.1.4. үнэт цаасны ханшийг бусадтай үгсэн хуйвалдаж зохиомлоор тогтоон барих, өсгөх, бууруулах үйлдэл хийх;

3.1.5. үнэт цаасны арилжааны явцад өмчлөгч нь өөрчлөгдөөгүй, нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд үнэт цаасны үнэ, ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах зорилгоор гүйлгээ хийх;

3.1.6. тухайн үнэт цаасны арилжаа идэвхтэй явагдаж байгаа мэтээр олон нийтийг төөрөгдүүлэх зорилгоор брокер, дилерийн болон нэгдмэл сонирхолтой бусад этгээдийн хооронд давхар гүйлгээ хийх;

3.1.7. үнэт цаасыг бүртгэх тухай Хорооны шийдвэр гарахаас өмнө үнэт цаасыг нийтэд санал болгох, сурталчлах;

3.1.8. харилцагчийн өгсөн буюу өгөх гэж буй нь баттай мэдэгдэж буй захиалга нь тухайн үнэт цаасны зах зээлийн үнэ ханшид нөлөөлөхүйц тохиолдолд тухайн захиалгыг хүлээн авч буй брокерийн компани өөрийн дансаар тухайн үнэт цаасыг худалдах, худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах, худалдан авахыг ятгах;

3.1.9. үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд тараагдаагүй дотоод мэдээллийг олж авсан зохицуулалттай этгээд нь өөрийн дансаар тухайн үнэт цаасыг худалдах, худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах, худалдан авахыг ятгах;

3.1.10. өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор үнэт цаасны үнэ, арилжаалах нөхцөл, авах шимтгэлийн асуудлаар бусад брокер, дилерийн компанитай тохиролцох;

3.1.11. харилцагчийн өмчлөлд байгаа үнэт цаасны тоо хэмжээ, түүнтэй холбогдох нийтэд тараагдаагүй мэдээллийг тараах, өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр сонирхогч этгээдэд уг үнэт цаасыг худалдан авахыг санал болгох.

3.2. Энэ журмын 3.1-д зааснаас гадна брокер, дилерийн компани нь үнэт цаасны арилжаа, төлбөрийн явцад дараах зүйлсийг хориглоно:

3.2.1. биелүүлэх зорилгогүй захиалгыг арилжааны програмд оруулах, түүнд засвар хийх, захиалга биелэгдэхээс өмнө цуцлах зэргээр тухайн үнэт цаасыг эрэлт, нийлүүлэлттэй мэт зохиомлоор харагдуулах үйлдэл хийх;

3.2.2. харилцагчийн өгсөн үнэт цаас худалдах болон худалдан авах захиалгын хүчинтэй байх хугацааг харилцагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөх;

3.2.3. арилжааны сүүлийн нэг цагийн туршид үнэт цаасны хаалтын ханшид нөлөөлөх зорилгоор худалдах, худалдан авах гүйгээг хийх;

3.2.4. арилжаа эрхлэх байгууллагаас олгосон системд нэвтрэх нэр, нууц дугаарыг хууль бусаар бусдад дамжуулах;

3.2.5. харилцагчийн мөнгөн хөрөнгийг үл тусгаарлах, түүнд төлбөрийн данс нээлгүйгээр арилжаанд оролцуулах;

3.2.6. хууль тогтоомжид заасан үндэслэлээр бизнесийн хэлцэл хийхийг хориглосон аливаа хуулийн этгээд, хувь хүнд харилцагчийн данс нээх;

3.2.7. арилжааны системийн мэдээллийн нууцлалыг алдагдуулах, урвуулан ашиглах;

3.2.8. харилцагчийн мөнгөн хөрөнгөөс брокерийн компанийн бусдын өмнө хүлээсэн үүргийг гүйцэтгэх;

3.2.9. Хороонд бүртгүүлэлгүй гадаад улсын үнэт цаасны зах зээлээс үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг эрхлэх.

Дөрөв. Харилцагчтай байгуулах гэрээ

4.1. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь харилцагчдад үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйлчилгээг үзүүлэх зорилгоор түүний нэрийн өмнөөс “ҮЦТТТХТ” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид данс нээлгэнэ.

4.2. Харилцагчийн дансыг нээхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

4.2.1. иргэн бол данс нээх гэрээ, иргэний үнэмлэхний хуулбар, түүнтэй адилтгах баримт бичиг;

4.2.2. хуулийн этгээд бол данс нээлгэх тухай албан хүсэлт, Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хуулийн этгээдийн уг данс дахь хөрөнгийг захиран зарцуулах этгээдийг томилсон тухай эрх бүхий этгээдийн тодорхойлолт;

4.2.3. өөрийн биеэр хүрэлцэн ирэх боломжгүй дотоод болон гадаадын иргэн нь иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг, хуулийн этгээдийн хувьд хуулийн этгээдийн бүртгэлийг тухайн улсын нотариатчаар гэрчлүүлсэн бичиг баримт.

4.2.4. данс нээх гэрээнд уг гэрээг цуцлах нөхцөл, эрх, үүрэг хариуцлагыг тусган гурван хувь үйлдэж, /харилцагч, брокерийн компани, “ҮЦТТТХТ” ХХК/ харилцагч, брокерийн компанийн гүйцэтгэх захирал нар гарын үсэг зурснаар уг гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээний нэг хувийг брокерийн компани архивлан хадгална.

4.3. Харилцагчийн төлбөр гүйцэтгэгч банкинд данс нээх ажилбарыг хөнгөвчлөх зорилгоор брокерийн компани нь шаардлагатай бичиг баримтыг харилцагчаас бүрдүүлэн, төлбөр гүйцэтгэгч банкинд данс нээлгэх ажлыг гүйцэтгэж болно. Төлбөр гүйцэтгэгч банк нь энэхүү журмын 4.2.1, 4.2.2, 4.2.3-д заасан бичиг баримтыг үндэслэн харилцагчдад төлбөрийн данс нээнэ.

4.4. Брокерийн компани нь нэмэлт нөхцөлтэй зуучлалын үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тухайн харилцагчтай байгуулна. Уг гэрээний маягыг тухайн брокерийн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол Хувь нийлүүлэгчдийн хурал/, эсхүл гүйцэтгэх захирал батална.

4.5. Уг гэрээнд дараах зүйлсийг тусгахыг хориглоно. Үүнд:

4.5.1. брокерийн компанийн хууль бус үйл ажиллагааны улмаас харилцагчид хохирол учруулснаас үүсэх хариуцлагын хязгаарлалт, учирсан хохирлыг барагдуулах төлбөрийн дээд хэмжээг заах;

4.5.2. харилцагчийн хууль тогтоомж болон гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлэх, гэрээг цуцлах эрхийг хязгаарлах, эсхүл аль нэг талд давуу эрх олгох;

4.5.3. Иргэний хуулийн 198.1 дэх заалтын дагуу үгийн шууд утгаар харилцагчид ойлгогдох боломжгүй, маргаан гарсан тохиолдолд өөрт ашигтай утгаар тайлбарлах боломжтой заалт.

4.6. Харилцагчтай байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээг үндэслэн тухайн харилцагчийн талаарх дараах мэдээллийг харилцагчийн ерөнхий бүртгэлд бүртгэнэ. Үүнд:

4.6.1. харилцагч иргэн бол овог, нэр, регистрийн дугаар, гадаадын иргэн бол гадаад паспортын дугаар, албан ёсны болон оршин суугаа хаяг, утасны дугаар;

4.6.2. харилцагч хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, хаяг, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаар, гадаадын иргэн бол гадаад паспортын дугаар;

4.6.3. брокерийн компаниас тогтоосон бусад мэдээлэл.

4.7. Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж, энэхүү журмын 3.1.4, 3.1.5, 3.1.6 дахь заалтуудыг зөрчих нөхцөлтэй захиалгыг биелүүлэхгүй талаар харилцагчтай байгуулах гэрээнд тусгаж болно.

4.8. Зохицуулалттай этгээд нь Хорооны даргын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр номинал дансаар дамжуулан харилцагчдад брокерийн үйлчилгээг үзүүлж болно. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 159-р тогтоолоор нэмсэн/*

4.9. Зохицуулалттай этгээд нь номинал данс эзэмших зөвшөөрөл авахдаа дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна: *Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 159-р тогтоолоор нэмсэн/*

4.9.1. 400 сая төгрөгөөс доошгүй хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх;

4.9.2. үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн бэк оффисийн /back office/ програмтай байх ба тус програм нь арилжаа эрхлэх, төлбөр тооцоо хадгаламжийн байгууллагын системд нийцсэн, тэдгээрийн шаардлагыг хангасан байх;

4.9.3. үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн чиглэлээр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх бүхий номинал данс хариуцсан мэргэжилтэнтэй байх бөгөөд тэрээр тусгай зөвшөөрөл бүхий компанийн гүйцэтгэх удирдлага, мэргэжилтнээр хавсран ажилладаггүй байх;

4.9.4. харилцагчийн мөнгөн хөрөнгийн бүртгэл, арилжааны мэдээллийг сар бүр тогтмол Хороонд ирүүлж байх.

4.10. Энэхүү журмын 4.9-д заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол Хорооны дарга тухайн брокерийн компанид номинал данс эзэмших зөвшөөрөл олгохоос татгалзана” *Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 159-р тогтоолоор нэмсэн/*

Тав. Харилцагчийг мэдээллээр хангах

5.1. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь харилцагчдад үнэт цаас худалдах, худалдан авах талаар шийдвэр гаргахад шаардлагатай дараах мэдээллээр хангах үүргийг хүлээнэ. Үүнд:

5.1.1. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан үнэт цаасны сүүлийн зургаан сарын арилжааны идэвх, үнэ ханш, арилжаатай холбоотой мэдээ;

5.1.2. үнэт цаас гаргагчийн хаяг, ерөнхий болон санхүүгийн байдлын талаарх мэдээлэл /Үүнд тухайн үнэт цаас гаргагчаас нийтэд мэдээлэхээр заасан санхүүгийн мэдээллүүд хамаарна/;

5.1.3. нийтэд мэдээлэхийг хуулиар хориглоогүй бусад мэдээлэл.

5.2 Брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь харилцагчийг зөвхөн мэдээллээр хангах үүрэг хүлээх бөгөөд үнэт цаас худалдан авах, худалдахтай холбоотой аливаа зөвлөгөө өгсөн тохиолдолд түүнийг тусгай зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх ба энэ нь брокерийн компанийн тухайн хөрөнгө оруулагчид учруулсан хохирлыг барагдуулах үүргээс чөлөөлөхгүй.

Зургаа. Харилцагчийн захиалга хүлээн авах

6.1. Брокерийн компанийн мэргэжилтэн нь харилцагчийн даалгаврыг гэрээнд заасан нөхцлийн дагуу гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд гэрээний нөхцөл өөрчлөгдөх тохиолдолд энэ тухай харилцагчид мэдэгдэх үүрэгтэй.

6.2. Захиалга өгч буй этгээд тухайн дансанд буй эд хөрөнгийг хууль ёсоор захиран зарцуулах эрхтэй эсэхийг брокерийн компанийн мэргэжилтэн урьдчилан шалгаж, уг харилцагчид захиалгыг биелүүлэх электрон арилжааны талаар танилцуулсны үндсэн дээр захиалгыг хүлээн авна.

6.3. Захиалга өгөх харилцагч нь иргэн бол тухайн дансанд буй үнэт цаасны хууль ёсны данс эзэмшигч, хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эсхүл тэдгээрийг хууль ёсоор төлөөлөх этгээд байна. Насанд хүрээгүй хүүхдийн дансаар гүйлгээ хийх тохиолдолд данс эзэмшигчийн хууль ёсны төлөөллийг нотлох бичиг баримтын шаардлагыг хангасан байна.

6.4. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь дилерийн үйл ажиллагаа давхар эрхэлж байгаа эсэхээс үл хамаарч харилцагчийн даалгаврыг тэргүүн ээлжид биелүүлэх, харилцагчийн захиалгыг өгсөн хугацааны дарааллын дагуу гүйцэтгэнэ.

6.5. Брокер нь харилцагчийн захиалгыг хүлээн авахаас өмнө сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар урьдчилан мэдэгдэх, захиалга хүлээн авсны дараа сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухай харилцагчид нэн даруй мэдэгдэх үүргийг хүлээнэ.

6.6. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь сонирхлын зөрчлийн талаар нэн даруй мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг тухайн брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд хариуцна.

6.7. Брокер нь харилцагчийн захиалгыг хүлээн авч тухайн захиалгыг бичгээр, эсхүл дуу болон дүрст бичлэгээр баталгаажуулан захиалгын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

6.8. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь харилцагчтай байгуулах захиалгын баримтад дараах нөхцлийг тусгасан байна. Үүнд:

6.8.1. үнэт цаасны нэр, код;

6.8.2. үнэт цаасны тоо ширхэг;

6.8.3. захиалгын нөхцөл, тодотгол, хүчинтэй байх хугацаа. /Хүчинтэй хугацааг заагаагүй буюу тодотголгүй захиалгын хувьд тухайн захиалга ажлын нэг хоногийн хугацаанд хүчинтэй байна/.

6.9. Дуу болон дүрст бичлэг нь тухайн харилцагчийн захиалга өгсөн цаг хугацааг нотолж чадахуйц байна.

6.10. Захиалгыг утсаар, цахим шуудангаар болон бусад хэлбэрээр авах, дуу болон дүрст бичлэг, цахим хэлбэрээр баталгаажуулах харилцаа нь брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээдийн болон арилжаа эрхлэх байгууллагын дотоод журмаар тус тус зохицуулагдана.

6.11. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь цахим арилжаанд оролцохдоо дараах шаардлагыг хангасан програм, хангамжийг ашиглана.

6.11.1. харилцагч зөвхөн өөрийн сонгосон нууцлалаар нэвтэрч, цахим арилжаанд оролцоход шаардлагатай баталгаажуулалтын кодын системтэй байх;

6.11.2. харилцагчийн нууц үг нь тухайн харилцагчаас бусад этгээд /брокерийн компанийн ажилтныг оролцуулан/ мэдэх боломжгүй байхаар програмчлагдсан байх;

6.12. Брокерийн компанийн компьютерийн програмын алдаанаас шалтгаалан харилцагчийн захиалгыг биелүүлээгүй нь гэрээ зөрчсөн гэж үзэх үндэслэл болно.

6.13. Бичгээр өгсөн захиалгын баримтыг брокерийн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол Хувь нийлүүлэгчдийн хурал/, эсхүл гүйцэтгэх захирлын баталсан маягтын дагуу хоёр хувь үйлдэх бөгөөд харилцагч, брокерийн компани тус бүр нэг хувийг хадгална.

6.14. Бичгээр өгсөн захиалгын баримтад захиалга өгсөн харилцагчийн нэр, регистрийн дугаар, гадаадын иргэн бол гадаад паспортын дугаар, гарын үсэг, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, тэмдэг, төлөөлөх эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал, захиалга хүлээн авсан брокерийн нэр, гарын үсэг, гэрээ байгуулсан огноо, цаг минутыг тусгах бөгөөд харилцагчийн захиалгад тусгайлан хэрэглэгдэх брокерийн компанийн тэмдэг дарж баталгаажуулна. Эдгээрийн аль нэг нь байхгүй байгаа нь гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болно.

6.15. Арилжааны үеэр харилцагч брокерийн компанид утсаар захиалга өгсөн тохиолдолд энэхүү журмын 6.10-т заасныг баримтална.

6.16. Үнэт цаас худалдах, худалдан авах захиалга нь хуанлийн гучин хоног хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна. Тухайн захиалгын нөхцлөөс шалтгаалан захиалгын хүчинтэй хугацаа өөр байх бөгөөд тус харилцаа нь арилжаа эрхлэх байгууллагын дотоод журмаар зохицуулагдана.

6.17. Брокерийн компанийн ажилтан үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж зөрчих нөхцөлтэй харилцагчийн захиалгыг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

Долоо. Захиалга биелүүлэх ажиллагаа

7.1. Харилцагчийн захиалгыг хүлээн авсан брокерийн компани нь захиалгыг Улаанбаатар хотод ажлын нэг өдөр, орон нутагт ажлын гурван өдөрт багтааж энэхүү журмын 1 дүгээр хавсралтын маягтын дагуу үйлдэж, дилерийн даалгаварт тусгуулан, арилжааны брокерт шилжүүлнэ.

7.2. Брокерийн компанийн салбар нь тухайн салбарыг илэрхийлсэн кодын дагуу захиалгыг дугаарлана.

7.3. Харилцагч цахим хэлбэрээр үнэт цаасны арилжаанд оролцохоос бусад бүх захиалгыг үнийн болон цаг хугацааны дарааллаар нэгтгэн дилерийн даалгаварт арилжаа эхлэхээс нэг цагийн өмнө тусгана. Харилцагч захиалгад өөрчлөлт оруулсан бол захиалгыг хүлээн авсан брокер нь арилжаанд сууж буй брокерт мэдэгдэн зохих өөрчлөлтийг нэн даруй оруулна.

7.4. Нээлтийн дуудлага арилжааны үед оруулсан харилцагчийн захиалгууд нь дуудлага арилжааны алгоритмын дагуу, энгийн арилжааны үед оруулсан захиалгууд нь ханшийн болон цаг хугацааны эрэмбэ дарааллын дагуу биелэгдэнэ.

7.5. Ижил нөхцөлтэй захиалгыг үнэт цаас худалдан авахад үнийн дээд, худалдахад үнийн доод хэмжээг үндэслэнэ. Харин үнэ тэнцсэн тохиолдолд хугацааны дарааллаар тус тус биелэнэ.

7.6. Харилцагчийн хойшлуулах болзолтойгоор өгсөн захиалгын баримтад заасан нөхцөл бий болж, эрх үүрэг нь үүссэний дараа брокерийн компани нь захиалгыг дилерийн даалгаварт тусгана. Энэ хүртэл брокерийн компани нь хойшлуулах болзолтойгоор өгсөн захиалгыг бүртгэж, болзолд заасан нөхцөл бий болсон эсэхэд байнга хяналт тавина.

Найм. Харилцагчийн захиалгыг өөрчлөх, цуцлах, дуусгавар болгох

8.1. Харилцагч болон брокерийн компанийн мэргэжилтэн электрон арилжааны санд хадгалагдаж буй биелэгдээгүй захиалгыг арилжааны холбогдох үе шатанд цуцлах, эсхүл тухайн захиалгын нөхцлийг өөрчлөх боломжтой бөгөөд энэ нь арилжаа эрхлэгч байгууллагын арилжааны журмаар зохицуулагдана.

8.2. Харилцагч өөрийн захиалгыг цуцлахыг хүссэн тохиолдолд энэ тухай брокерийн компанид мэдэгдэх бөгөөд брокерийн компанийн мэргэжилтэн энэ талаар захиалгын баримт болон дилерийн даалгаварт тэмдэглэл хийж баталгаажуулна.

8.3. Харилцагчийн захиалга дараах тохиолдолд дуусгавар болно: Үүнд:

8.3.1. захиалга бүрэн биелэгдсэн;

8.3.2. зах зээлийн захиалгын хувьд гэрээнд заасан үнэт цаасыг худалдан авах мөнгөний дээд хэмжээнд хүрсэн, төлбөрийн дансанд байршуулсан мөнгө дууссан;

8.3.3. захиалгын гэрээний үйлчлэх хугацаа дууссан;

8.3.4. харилцагч үнэт цаасны таван удаагийн арилжааны явцад өөрийн захиалга биелүүлэхгүй байхыг хүссэн тохиолдолд үнэт цаасны арилжаанд оролцохоос татгалзсан сүүлчийн өдрөөр тасалбар болгоно.

8.4. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь арилжаанд тогтмол оролцдог харилцагчийн дансаар хийгдэх гүйлгээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчиж буй эсэхэд хяналт тавих үүрэгтэй бөгөөд энэ харилцааг байгууллагын дотоод журмаар зохицуулна.

Ес: Компанийн хөрөнгөөр үнэт цаасны арилжаанд оролцох

9.1. Дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, компанийн дүрэмд заасан бусад эрх бүхий этгээдийн шийдвэрээр өөрийн хөрөнгөөр үнэт цаас худалдан авах, түүнийг худалдах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

9.2. Удирдлагын шийдвэрийг үндэслэн энэхүү журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу үйлдсэн “компанийн хөрөнгөөр үнэт цаас худалдан авах, худалдах дилерийн даалгавар”-аар дилер арилжаанд оролцох бөгөөд арилжааны явцад үнэт цаас худалдан авах, худалдах шийдвэр гаргах эрхийг гүйцэтгэх удирдлагаас дилерт бичгээр олгож болно.

9.3. Дилер энэ журмын 9.2-т заасан шийдвэрийг гаргасан бол энэ тухай дилерийн даалгаварт тухай бүр тэмдэглэн, удирдлагуудад танилцуулна.

9.4. Дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь өөрийн хөрөнгөөр үнэт цаас худалдан авах, худалдах дараах нөхцлийг тусгасан дилерийн даалгаврыг арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

9.4.1. худалдах, худалдан авах үнэт цаасны үнэ, тоо ширхэг;

9.4.2. худалдах, худалдан авахаар санал болгож буй үнийн хүчинтэй байх хугацаа.

9.5. Дилер нь дээрх журмын 9.4-д заасан нөхцлийг арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу өөрчлөх буюу цуцалж болох бөгөөд дилерийн үнэт цаас худалдан авах, худалдах нөхцлийг зөвшөөрсөн тохиолдолд тэрээр үл маргах журмаар биелүүлэх үүрэгтэй.

9.6. Брокер, дилерийн үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь харилцагчийн тухайн үнэт цаасанд хамаарах захиалгыг бүрэн биелүүлсний дараа өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн захиалгыг биелүүлнэ.

~~Ес¹. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх тухай~~

~~/ Энэ хэсэг (9.1¹- 9.6¹) –ийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 198 дугаар тогтоолоор нэмсэн/~~

~~/Энэ хэсэг (9.1¹-9.6¹)-ийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 102 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

~~9.1¹. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.16-д заасны дагуу брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.~~

~~9.2¹. Энэхүү журмын 9.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл хүсч буй зохицуулалттай этгээд нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:~~

~~9.2.1¹. 200.0 сая төгрөгөөс доошгүй хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх;~~

~~9.2.2¹. үнэт цаасны толбор тооцоо, бүртгэлийн бэж оффис /back office/ -ийн програмтай байх ба тус програм нь гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх, толбор тооцоо, хадгаламжийн байгууллагын болон кастодиан банкны системд нийцсэн, тухайн улсын хадгаламжийн байгууллагын дүрэм, журамд нийцүүлэн харилцагчийн хөрөнгийн бүртгэлийг хөтөлдөг байх;~~

~~9.2.3¹. энэхүү журмын 9.2.2-д заасан програм нь харилцагч өөрийн данс дахь хөрөнгийн талаарх мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр авах боломжоор хангасан байх;~~

~~9.2.4¹. харилцагчийн данс хариуцсан мэргэжилтэнтэй байх ба уг мэргэжилтэн нь үнэт цаасны толбор тооцоо, бүртгэлийн чиглэлээр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй байх;~~

~~9.2.5¹. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.8-д заасны дагуу харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлан харилцагч тус бүрээр тусгайлан, нэр төрлөөр нь балансын гадуур дэлгэрэнгүй бүртгэж байх; /Харилцагчийн гадаад улсын үнэт цаасны зах зээлээс үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгө, худалдан авсан үнэт цаас, түүнтэй холбоотой орлогыг тайлангийн тодруулгын “балансын гадуурх бүртгэлийн тодруулга” хэсэгт тусгана./~~

~~9.2.6¹. гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах брокерийн үйл ажиллагаа эрхлэх тухай дотоод журмыг компанийн эрх бүхий этгээдээр батлуулан байх;~~

~~9.2.7¹. харилцагчийн мөнгөн хөрөнгийн бүртгэл, арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн ерөнхий мэдээллийг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байх.~~

~~9.3¹. Энэхүү журмын 9.2-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан зохицуулалттай этгээдэд гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлахыг Хорөө зөвшөөрнө.~~

~~9.4¹. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах этгээд нь харилцагчийн захиалгыг биелүүлэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-36.15 дахь хэсгүүдийг мөрдөж ажиллана.~~

~~9.5¹. Энэхүү журмын 9.1-д заасан үйл ажиллагааг Хорооны зөвшөөрөлгүй эрхэлсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.~~

~~9.6¹. Энэхүү журмын 9.2-д заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол захиргааны хариуцлага ногдуулж, энэ журмын 9.1-д заасан зөвшөөрлийг хүчингүй болгоно.”.~~

Арав: Андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны зохицуулалт

10.1. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь үнэт цаас гаргагч этгээдтэй дараах зүйлийг тусгасан үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажиллана: Үүнд:

10.1.1. гэрээ хүчин төгөлдөр байх хугацаа;

10.1.2. талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

10.1.3. нийтэд санал болгож буй үнэт цаасны захиалгын хугацаа;

10.1.4. үйлчилгээний шимтгэлийн хэмжээ;

10.1.5. уг гэрээнд андеррайтерийн үйлчилгээний дараах төрлүүдээс аль нэг, эсхүл хосолсон хэлбэрээр хамтран ажиллахыг тусгана. Үүнд:

10.1.5.1. хоёрдогч зах зээлд худалдах буюу өөрийн үнэт цаасны багцад хадгалах зорилгоор үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасыг бүхэлд нь худалдан авах;

10.1.5.2. үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасны зарим хэсгийг худалдан авах;

10.1.5.3. гаргасан үнэт цаасыг худалдан авахгүйгээр дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд арилжих үйл ажиллагааг зохион байгуулах;

10.1.5.4. анхдагч зах зээлд арилжигдаагүй үнэт цаасыг тогтоосон үнээр худалдан авах баталгаа гаргах.

10.1.6. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээдүүд нь хамтын ажиллагааны гэрээний дагуу андеррайтерийн үйлчилгээг эрхэлж болно.

10.2. Хөрөнгө оруулалтын зөвлөх компани нь дараах нөхцөл, шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана:

10.2.1. хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүрээнд харилцагчид үнэт цаасыг худалдах, худалдан авах үнэ, нөхцөл, хугацааны талаар зөвлөгөө өгөхдөө холбогдох статистик тоо баримт, судалгаа шинжилгээний бүхий л баримт судалгааг танилцуулах;

10.2.2. харилцагчид өгөх зөвлөгөөг зөвхөн үнэн тоо баримт, зах зээлийн бодит байдал тулгуурлан боловсруулах бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу дүн шинжилгээ хийсэн байх;

10.2.3. компанийн ажилтан нь зөвлөх үйлчилгээний хүрээнд харилцагчид санал болгож буй үнэт цаасны өмчлөгч буюу тухайн үнэт цаасыг гаргагчтай ашиг сонирхолын зөрчил үүссэн тохиолдолд энэ тухайгаа харилцагчид нэн даруй мэдэгдэх;

10.2.4. харилцагчтай гэрээ байгуулахаас өмнө компанийн тусгай зөвшөөрөл, санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой баримт, зөвлөх ажилтан нь сүүлийн таван жилийн хугацаанд Хороо болон хууль хяналтын байгууллагаас өөрийн үүрэгт ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор захиргааны болон эрүүгийн шийтгэлээр шийтгүүлсэн эсэх тухай мэдээллийг харилцагчид гаргаж өгөх;

10.2.5. харилцагчийн санхүүгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын туршлага, хөрөнгө оруулалтын объектийн талаар судалгаа хийсний үндсэн дээр зөвлөгөө өгөх;

10.2.6. харилцагчид өгөх зөвлөгөөг бие даасан, хараат бус байдлаар боловсруулах;

10.2.7. харилцагчид зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд гарч болох эрсдлийг тодорхойлж, түүнээс сэргийлэх, зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий ажилтнууд холбогдох хууль тогтоомжийн дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх тогтолцоог бүрдүүлсэн дотоод хяналтын журам баталж, мөрдүүлэх;

10.2.8. энэ журмын 10.2.7-д заасан журмын хэрэгжилтын талаар Хороонд улирал тутам тайлагнах.

Арван нэг. Үнэт цаасны төлбөр

11.1. Үнэт цаасны төлбөр нь мөнгөн хөрөнгийн гүйлгээнээс бүрдэнэ. Төвлөрсөн хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээний мөнгөн хөрөнгийн орлого нь арилжааны банкнаас хадгаламжийн байгууллагын дансанд хийгдсэн гүйлгээ, зарлага нь хадгаламжийн байгууллагын данснаас арилжааны банкны дансруу хийгдсэн гүйлгээг тус тус ойлгох бөгөөд нарийвчилсан харилцааг хадгаламжийн байгууллагын журмаар зохицуулна.

11.3. Үнэт цаасны арилжааны төлбөрийг төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлбөр гүйцэтгэх банк гүйцэтгэх бөгөөд брокер, дилерийн тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь тухайн харилцагчийн үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөрийг гүйцэтгүүлэх зорилгоор төлбөр гүйцэтгэх банкинд тусгайлсан данс нээлгэнэ.

11.4. Брокерийн компанийн харилцагч нь арилжааны банкин дахь үнэт цаасны худалдах, худалдан авах дансанд үнэт цаасны төлбөрийг гучаас доошгүй хувиар урьдчилан байршуулах бөгөөд тухайн дансан дахь мөнгөн хөрөнгийн урьдчилгааны хувь, захиран зарцуулах эрхийг брокерийн компани, харилцагчийн хооронд байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээгээр зохицуулна.

11.5. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага нь үнэт цаасны төлбөр, мөнгөн хөрөнгийн гүйлгээний баримт хүлээн авсан дэс дарааллыг баримтлан тооцоог цахим тооцоолуурын сүлжээний тусламжтайгаар гүйцэтгэнэ.

11.6. Анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасны арилжааны төлбөртэй холбоотой мөнгөн хөрөнгийн гүйлгээг тухайн үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага гүйцэтгэнэ.

11.7. Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь үнэт цаасны арилжааны төлбөрийг гүйцэтгэхийн тулд дараах нөхцлийг хангаж ажиллана. Үүнд:

11.7.1. харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусад нь байршуулах;

11.7.2. үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагаас тогтоосон хэмжээний барьцаа хөрөнгийг тухайн төлбөр гүйцэтгэх банкинд байршуулах;

11.7.3. үнэт цаасны арилжааны төлбөрийг тасралтгүй, хэвийн явуулах, үнэт цаасны зах зээлийн тогтвортой байдлыг хангах, төлбөр гүйцэтгэх банкны эрсдлийг бууруулах зорилгоор “Төлбөрийн баталгааны сан”-д мөнгөн хөрөнгө байршуулах;

11.7.4. өөрийн болон харилцагчийн хийсэн арилжааны төлбөрийн гүйцэтгэлийг хангах үүргийг хүлээх /Энэхүү үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд төлбөр гүйцэтгэгч банкинд байрших төлбөрийн болон барьцаа хөрөнгийн данснаас суутгах, эзэмшлийн үнэт цаасыг нь худалдах, “Төлбөрийн баталгааны сан”-гаас холбогдох журмын дагуу санхүүжилт авах зэргээр хохирлыг барагдуулна/;

11.7.5. брокер, дилерийн компани нь өөрийн болон харилцагчийн дансны бүртгэлийг үнэн зөв хөтөлж, төвлөрсөн хадгаламж дахь үнэт цаас, мөнгөн хөрөнгийн гүйлгээний мэдээ, тайланг гаргаж, харилцагчийг мэдээллээр хангаж ажиллах;

Арван хоёр. Үйл ажиллагааны шимтгэл

12.1. Зохицуулалттай этгээд нь харилцагчаас үйлчилгээний шимтгэл авах бөгөөд түүнийг тооцох аргачлал, зааврыг дотоод үйл ажиллагааны журмаар тогтоож, мөрдөх ба уг журам нь Хорооны журам, зааварт нийцсэн байна.

12.2. Брокерийн компани нь харилцагчийн үйлчилгээний шимтгэлийн хэмжээнд өөрчлөлт орсон тухай бүр хадгаламжийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

12.3. Хөрөнгө оруулалтын зөвлөхийн компани зөвлөх үйлчилгээний тарифын хэмжээнд орсон өөрчлөлтийг тухай бүр Хороонд мэдээлнэ.

Арван гурав. Харилцагчдад мэдээлэл хүргэх

13.1. Харилцагчтай гэрээ байгуулахын өмнө брокерийн болон хөрөнгө оруулалтын зөвлөх компани нь үнэт цаасны зах зээлийн талаарх ерөнхий ойлголт өгөх зорилгоор дараах мэдээллийг танилцуулсан байна.

13.1.1. үнэт цаасны арилжааны захиалга, хэлцэл хийгдэх явц, электрон арилжааны систем талаарх;

13.1.2. үнэт цаас худалдах, худалдан авахад хүлээж болох зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэл;

13.1.3. компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг худалдан авсан этгээд уг үнэт цаасыг худалдан авснаас хойш ажлын арав хоногийн дотор Хороонд мэдэгдэх зэрэг хуулийн дагуу үүсэх үүрэг хариуцлагууд.

13.2. Брокерийн компани нь харилцагчийн өгсөн захиалга биелэгдэхэд түүнд үнэт цаасны нэр, үсгэн код, хэлцэл хийгдсэн огноо, үнэ, тоо ширхэг, шимтгэлийн талаарх мэдээллийг харилцагчийн гэрээнд заасан цахим шуудан, утас, факс, бусад боломжит харилцаа холбооны хэрэгслээр нэн даруй мэдэгдэнэ:

13.3. Харилцагч шаардсан тохиолдолд брокерийн компани нь харилцагчийн дансны хуулгыг цахим шуудангаар явуулах буюу эсхүл харилцагч нууц үгийн тусламжтайгаар брокерийн компанийн сайтад нэвтрэн орж өөрийн дансыг байнга шалгах боломжоор хангана.

13.4. Зохицуулалттай этгээд нь харилцагчийн шаардсанаар өөрийн компанийн талаарх дараах баримт болон мэдээллээр хангах үүрэгтэй: Үүнд:

13.4.1. тухайн компанийн үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон улсын бүртгэлийн гэрчилгээтэй холбогдсон бичиг баримт;

13.4.2. компанийн санхүүгийн байдлын талаарх мэдээлэл;

13.4.3. гүйцэтгэх захирал, дотоод хяналтын ажилтан, мэргэжилтнүүд нь мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор арга хэмжээ авагдсан, хариуцлага хүлээсэн эсэх тухай мэдээлэл.

Арван дөрөв. Зар сурталчилгаа

14.1. Зохицуулалттай этгээд нь үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах болон хоёрдогч зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, холбогдох үйлчилгээг санал болгохдоо нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон утас, интернет, цахим шуудан, хэвлэмэл хуудас зэрэг хэлбэрээр зар сурталчилгаа явуулж болно.

14.2. Зар сурталчилгаа нь бодит байдалд нийцсэн байх бөгөөд төөрөгдүүлсэн, үндэслэлгүй мэдээлэл агуулаагүй байх бөгөөд тухайн зохицуулалттай этгээдийн гишүүнчлэл бүхий өөрийгөө зохицуулах байгууллага үүнд хяналт тавина.

14.3. Зохицуулалттай этгээд нь гуравдагч этгээдээс авсан аливаа мэдээллийг зар сурталчилгаандаа түүнийг үндэслэлтэй эсэхийг шалгасны үндсэн дээр иш татаж ашиглана.

14.4. Иш таталгүйгээр ашигласан мэдээлэл нь бодит байдалд нийцээгүйн улмаас аливаа этгээдэд учирсан хохирлыг зохицуулалттай этгээд хариуцна.

Арван тав. Дотоод хяналт

15.1. Зохицуулалттай этгээд нь Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д заасны дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэх журамтай байх ба дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотойгоор хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтны үүрэг, хариуцлагыг зааглан тодорхойлсон байна.

15.2. Зохицуулалттай этгээдийн дотоод хяналтын тогтолцоо нь түүний нягтлан бодох бүртгэл, эрсдлийн удирдлагыг бүрэн хамаарч чадахуйц, үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж болохуйцаар зохион байгуулагдсан байна.

15.3. Зохицуулалттай этгээдийн төв болон салбарын үйл ажиллагаа нь Үнэт цаасны зах зээлийн хууль, тогтоомж болон компанийн дотоод үйл ажиллагааны журмуудад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих орон тооны дотоод хяналтын ажилтантай байна.

15.4. Дотоод хяналтын ажилтан нь хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлэх ба эрх бүхий этгээд, удирдлагаас өгсөн үүрэг, даалгавраар тухайлсан шалгалтыг гүйцэтгэж болно. Дотоод хяналтын ажилтан нь шалгалтын тайлан, дүгнэлтийг тухай бүр хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д танилцуулна.

15.5. Дотоод хяналт шалгалтын тайланд шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулах талаар хугацаатай үүрэг, даалгавар, гүйцэтгэлийг хангуулах, хариуцлагын харилцааг тодорхой тусгасан байна.

15.6. Дотоод хяналтын ажилтан нь үр дүнтэй, шударга хяналтыг хэрэгжүүлж чадахуйц мэдлэг, туршлагатай байх ба компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь түүнийг бие даасан, хараат бус хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцлөөр хангах үүрэгтэй.

15.7. Дотоод хяналтын ажилтан нь компанийн бүх төрлийн бичиг баримт, бүртгэлийг шалгах эрхтэй, хөндлөнгийн аудитор, хянан шалгах зөвлөлд мэдээлэл өгөх үүрэгтэй байна.

15.8. Дотоод хяналтын ажилтан нь зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд эрсдлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, Хорооноос тогтоосон санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хангалт, эрсдлийн удирдлага, хяналтыг тогтмол мөрдүүлж ажиллана.

15.9. Дотоод хяналтын ажилтан нь зохицуулалттай этгээдийн ерөнхий болон хүний нөөц, санхүү, нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээлэлд орсон өөрчлөлтийг тухай бүр Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

15.10. Дотоод хяналтын ажилтан нь Хорооноос өгсөн үүрэг даалгавар болон улсын байцаагчийн албан шаардлагын биелэлт, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг Хороонд ирүүлэх үүрэгтэй.

15.11. Дотоод хяналтын ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүдэн харилцагчид хохирол учруулсан тохиолдолд тухайн зохицуулалттай этгээд хариуцна.

Арван зургаа. Бичиг баримт хадгалах

16.1. Зохицуулалттай этгээдийн бичиг баримтыг хадгалах, архивын нэгж болгох нийтлэг харилцааг Монгол Улсын Архивын тухай хуулиар, нарийвчилсан харилцааг арилжаа эрхлэх болон үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын дотоод журмаар зохицуулна.

16.2. Зохицуулалттай этгээд нь дараах бичиг баримтыг өөрийн архивт таваас доошгүй жилийн хугацаагаар хадгалах үүрэгтэй. Үүнд:

16.2.1. харилцагчтай байгуулсан данс нээх гэрээ, захиалгын гэрээ, харилцагчаа таньж мэдэх маягт, итгэмжлэл;

16.2.2. харилцагчийн ерөнхий мэдээллийн бүртгэл;

16.2.3. үнэт цаас худалдах, худалдан авах захиалгатай холбоотой бичиг баримт, дуу хоолойны болон дүрст бичлэг;

16.2.4. харилцагчийн дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой баримтууд;

16.2.5. андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой баримтууд;

16.2.6. хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой баримтууд;

16.2.7. санхүүгийн тайлан, түүний нэмэлт тодруулга;

16.2.8. компанийн холбогдох этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл;

16.2.9. өөрийн данс дахь үнэт цаас, мөнгөн хөрөнгө, тэдгээртэй холбоотой хэлцлийн бүртгэл;

16.2.10. дотоод хяналт шалгалтын тайлан, дүгнэлт, түүний үр дүнд хийгдсэн ажлын тайлан, холбогдох бичиг баримтууд.

16.2.11. харилцагчаас ирүүлсэн өргөдөл, гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал, тусгай зөвшөөрлийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой бичиг баримт, гэрээ хэлцэл зэрэг бусад бичиг баримтууд.

16.3. Энэхүү журмын 16.2-т заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд Монгол Улсын Архивын тухай хуулийн дагуу бичиг баримтыг холбогдох архивт шилжүүлнэ.

16.4. Зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд энэ журмын 16.2-т заасан бичиг баримтыг арилжаа эрхлэх болон үнэт цаасны хадгаламжийн байгууллагын архивт шилжүүлнэ.

Арван долоо. Хариуцлага

17.1. Зохицуулалттай этгээдийн мэргэжилтний хууль зөрчсөн үйлдлийг тухайн зохицуулалттай этгээдийн хууль зөрчсөн үйлдэл гэж үзэж захиргааны хариуцлага ногдуулна.

17.2. Энэ журмын холбогдох заалтыг зөрчсөн зохицуулалттай этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.

17.3. Энэ журамд заасан хориглох зүйл, холбогдох заалтыг зөрчсөн зохицуулалттай этгээдийн мэргэжилтний үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг хүчингүй болгож, зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн захиргааны шийтгэл оногдуулах бөгөөд цаашид захиргааны шийтгэлтэйд тооцогдох хугацаанд дахин зөрчил гаргасан тохиолдолд уг тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

-----oO-----

“Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны тухай журам”-ын 1 дүгээр хавсралт

**ҮЦК-ИЙН ХАРИЛЦАГЧИЙН ЗАХИАЛГЫГ
БИЕЛҮҮЛЭХ ДИЛЕРИЙН ДААЛГАВАР**

201.. оны .. сарын ..-ний өдрийн арилжаанд

Худалдах захиалга

Захиалгын гэрээний дугаар	Захиалга өгсөн огноо, цаг минут	Үнэт цаасны нэр /код/	Үнэт цаасны		Захиалгын нөхцөл	Дансны дугаар	Захиалгын биелэлт		Тэмдэглэл
			Үнэ	Тоо, ширхэг			Үнэ	Тоо, ширхэг	

Худалдан авах захиалга

Захиалгын гэрээний дугаар	Захиалга өгсөн огноо, цаг минут	Үнэт цаасны нэр /код/	Үнэт цаасны		Захиалгын нөхцөл	Дансны дугаар	Захиалгын биелэлт		Тэмдэглэл
			Үнэ	Тоо, ширхэг			Үнэ	Тоо, ширхэг	

Нэгтгэсэн -----/гарын үсэг/

Захиалга хянасан-----/гарын үсэг/

“Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны тухай журам”-ын 2 дугаар хавсралт

**ҮЦК-ИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР АРИЛЖААНД
ОРОЛЦОХ ДИЛЕРИЙН ДААЛГАВАР**

201.. оны .. сарын ..-ний өдрийн арилжаанд

Захиалга өгсөн огноо, цаг минут	Худалдах, худалдан авах аль болох	Үнэт цаасны нэр, төрөл /код/	Үнэт цаасны		Захиалгын төрөл, нөхцөл	Захиалгын биелэлт	
			Үнэ	Тоо, ширхэг		Үнэ	Тоо, ширхэг

Захиалга нэгтгэсэн -----/гарын үсэг/

“Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны тухай журам”-ын 3 дугаар хавсралт

Хуулийн этгээд

Харилцагчаа Таних (ХТ) маягт

Зохицуулалттай этгээдийн лого болон хаяг

Дансны ерөнхий мэдээлэл

Үүсгэн байгуулагдсан хэлбэр: Тэмдэглэнэ үү (✓)

Хязгаарлагдмал хариуцлагатай компани, Хувьцаат компани,
 Гадаадын хөрөнгө оруулалтын сан Дотоодын хөрөнгө оруулалтын сан
 Бусад: (Тодруулна уу)

Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл: Тэмдэглэнэ үү (✓) Дотоодын Гадаадын

а) МХБ-д бүртгэлтэй эсэх : Тэмдэглэнэ үү (✓) Тийм Үгүй
б) Бусад хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх : Тэмдэглэнэ үү (✓) Тийм Үгүй

Хэрэв бүртгэлтэй бол аль улсын хөрөнгийн бирж дээр вэ:.....

Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээлэл

Хуулийн этгээдийн нэр				
Хаяг				
Компанийн бүртгэлийн дугаар	Компани байгуулагдсан өдөр	Газар		
Утасны дугаар	Факсын дугаар			
Имэйл хаяг:				

Дансаар гүйлгээ хийх эрх бүхий этгээдүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл
/Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргах/

Нэр	Эрх хэмжээ

Холбоо барих

Онцгой тохиодолд холбоо барих этгээдийн нэр			
Утасны дугаар	(Албан)	(Гэрийн)	Гар утас
И-мэйл хаяг			Факсын дугаар

Бусад дэлгэрэнгүй мэдээлэл

а) Бизнесийн үйл ажиллагааны чиглэл (бүтээгдэхүүн/ үйлчилгээ):

.....

б) Жилд хийх хөрөнгө оруулалт болон арилжааны дүн: Тэмдэглэнэ үү (✓)

1,000,000 ₮ хүртэлх 1,000,001-ээс 5,000,000 ₮ 5,000,001-аас 10,000,000 ₮
 10,000,001-ээс 50,000,000 ₮ 50,000,001-ээс 100,000,000 ₮ 100,000,001-ээс 1,000,000,000 ₮
 1,000,000,000₮-өөс дээш

Санхүүжилтийн эх үүсвэр: Тэмдэглэнэ үү (✓)

Бизнесийн орлого Хөрөнгө оруулалт Борлуулалтын орлого Гэрээний орлого
 Өмч/ хөрөнгийн борлуулалт Бэлэг Шимтгэлийн Орлого Экспортын орлого
 Хөрөнгө оруулалтын орлого/Хадгаламж Хандив (Дотоод/Гадаад)
 Бусад (Тодруулна уу).....

Хамаарал бүхий бусад бизнес /Мэргэжлийн үйл ажиллагаа, бизнесийн ашиг сонирхол/

.....

Холбогдох бусад мэдээлэл:

.....

Төлбөр гүйцэтгэх заавар

<input type="checkbox"/>	Үнэт цаас борлуулсны орлогыг ирээдүйн төлбөрт хадгалж, дансанд үлдээх
<input type="checkbox"/>	Худалдах/ худалдан авах ажиллагааны төлбөрийг тухай бүр хийх

ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭГДЭЛ

1. Би/бид энэхүү өргөдөлд өгсөн мэдээлэл нь үнэн, зөв болохыг баталж байна.

2. Би/Бид [Брокер]-оор гүйцэтгүүлэх үнэт цаасны гүйлгээтэй холбогдох энэхүү зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн зохицуулах хорооны болон Монголын хөрөнгийн бирж, Төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагаас гаргасан журмуудтай (цаашид өөрчлөгдөж болно) танилцаж, сайтар ойлгосон гэдгээ мэдэгдэж байна.

3. Үнэт цаасны хэлцлийг (төлбөр нь төлөгдөөгүй хэлцлийг зохицуулах дүрэм журам г.м) зохицуулахтай холбоотой МХБ-ээс гаргасан дүрэм журмуудтай (цаашид өөрчлөгдөж болно) танилцаж, ойлгосон болохоо би/бид мэдэгдэж байна.

4. Би/бид худалдаж авсан үнэт цаасны төлбөрийг Т+3 буюу төлбөр тооцоо хийгдэх өдрөөс өмнө төлбөр тооцоо гүйцэтгэх банкид бүртгэлтэй миний/бидний үнэт цаасны арилжааны тусгай дансанд байршуулахаа мэдэгдэж байна. Хэрэв төлбөрөө хугацаанд нь байршуулж чадаагүй тохиолдолд, төлбөр тооцоо хийгдэх ёстой байсан өдрөөс төлбөр төлөгдөх өдөр хүртэлх хугацаанд хүүгийн торгууль (торгууль ногдуулах хамгийн дээд хувь ...) төлөхөө зөвшөөрч байна. Худалдан авсан үнэт цаасны төлбөрийг хугацаанд нь гүйцэтгэж чадаагүй тохиолдолд, төлбөр нь хийгдээгүй үнэт цаас болон ҮЦГТТХТ дэх миний/бидний дансан дахь төлбөр нь бүрэн төлөгдсөн аливаа үнэт цаасыг арилжиж, [Брокер]-т төлөх ёстой бүх төлбөрийг /худалдан авсан үнэт цаасны төлбөр, торгууль, хураамж г.м/ барагдуулах эрхийг [Брокер]-т олгож буйгаа хүлээн зөвшөөрч байна. Миний/бидний ҮЦГТТХТ дансанд буй үнэт цаасыг захиран зарцуулах эрхийг үүгээр [Брокер]-т олгож буйгаа би/бид ойлгож, зөвшөөрч байна.

5. [Брокер] нь миний/бидний үнэт цаас борлуулсны орлогыг ирээдүйн худалдан авалтын төлбөрт хадгалахыг Би/Бид зөвшөөрч байна.

- [Брокер] нь надад/бидэнд төлөх, надаар/ биднээр төлүүлэх төлбөрийн аль алинд нь эхэнд орсныг эхэлж зарлагадах төлбөрийн зарчмыг баримтална.
- [Брокер] нь миний/бидний дансанд тохируулах бичилт хийж, сар тус бүрийн эцэст төлбөр нь хүлээгдэж буй хэлцлүүдийг тодруулан дансны хуулгыг илгээнэ.

6. [Брокер] нь миний/бидний нэрийн өмнөөс (үнэт цаас худалдах/ худалдан авах зуучлагчийн үүргийн дагуу, эсвэл хувьцаанд хамаарах ногдол ашиг, үнэт цаас тэргүүн ээлжинд худалдан авах эрх, бонус болон бусад урамшуулалтай холбоотойгоор) гүйцэтгэсэн шууд/шууд бус гүйлгээтэй холбоотойгоор аливаа хохирол, алдагдал хүлээсэн тохиолдолд Би/Бид түүнийг хариуцаж, үүссэн алдагдал, хохирлоос [Брокер]-ийг чөлөөлнө гэдгээ үүгээр хүлээн зөвшөөрч байна.

7. ЭРСДЭЛ ХҮЛЭЭХ МЭДЭГДЭЛ: Үнэт цаасны ханш тогтмол хэлбэлздэг бөгөөд зарим тохиолдолд огцом өөрчлөгддөг. Үнэт цаасны ханш өсөх, буурах аль ч чигт өөрчлөгдөж болзошгүй бөгөөд бүр үнэгүйдэх ч магадлалтай. Үнэт цаасыг худалдан авч, худалдсаны дүнд ашиг олохоос илүүтэйгээр алдагдал хүлээх магадлалтай гэдгийг Би/Бид ойлгож байна.

[Брокер] нь дээрх бүх мэдэгдлүүд, түүний дотор ЭРСДЭЛ ХҮЛЭЭХ МЭДЭГДЛИЙГ надад/бидэнд тайлбарлаж ойлгуулсан бөгөөд Би/Бид уг нөхцлүүдийг уншиж, сайтар ойлгосон болохоо мэдэгдэж байна.

Нэр: Гарын үсэг:.....

Нэр: Гарын үсэг:.....

Огноо:

Гэрч: (1) Нэр: (2) Нэр:.....

Хаяг: Хаяг:.....

Гарын үсэг: Гарын үсэг:.....

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД	Холбогдох бүх бичиг баримтыг хавсаргасан.	Хөрөнгө оруулалтын зөвлөх		Гарын үсэг		Огноо	
	ТИЙМ/ҮГҮЙ	Системд оруулсан		Гарын үсэг		Огноо	

Дараах мэдээллийг хавсаргана уу:

1. Захирлуудын дэлгэрэнгүй мэдээлэл (Нэр/с, хаяг, мэргэжил) болон хамгийн том 10 хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн нарийн бичиг эсвэл Захирлаар баталгаажуулан албан бланк дээр тусад нь ирүүлэх.
2. Захирлуудын иргэний үнэмлэхийн хуулбар (нотариатаар баталгаажуулсан)
3. Компани үүсгэн байгуулагдсан дүрмийн баталгаажуулсан хуулбар
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (Зөвхөн данс нээлгэх маягтын “шийдвэрийг баталгаажуулах тухай” хэсгийг бөглөөгүй бол)
6. Хэрэв өргөдөл гаргагч компанийн өмнөөс түүний эрх бүхий этгээд ҮЦТТХТ-ийн өргөдлийн маягтад гарын үсэг зурж байгаа бол тухайн эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар

Хэрэв гадаадын компани бол дараах нэмэлт баримт бичгийг хавсаргана:

- I. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар (холбогдох тохиолдолд)
- II. Тухайн компанийн үүсгэн байгуулагдсан газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар буюу холбогдох засаг захиргааны газрын тодорхойлолтын баталгаажуулсан хуулбар

Анхаарна уу:

- Өргөдлийн маягтыг бөглөхдөө арилгагч ашиглаж болохгүй.
- Хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн тухайд дээрх 1, 2, 3-д дурьдсан баримт бичиг шаардлагагүй.
- Бүх дагалдах бичиг баримт нь эх хувийн үнэн хуулбар болохыг Компанийн Нарийн бичгийн дарга огноо тавьж гэрчилсэн байна.
- ҮЦТТХТ-ийн болон бусад холбогдох маягтуудыг хоёр захирал гарын үсэг зуран, компанийн нэртэй тамга дарж баталгаажуулсан байна.

Хувь хүн

Харилцагчаа таних (ХТ) маягт

Зохицуулалттай этгээдийн лого болон хаяг

Харилцагчийн дансны төрөл Хувь хүний Хамтын

Хувийн мэдээлэл

Овог нэр: (Ноён./Хатагтай)	
Байнгын оршин суух хаяг:	

Төрсөн огноо:	Харьяалал:		P Дугаар		
Холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл:	Гэрийн утас	Гар утас	Албаны утас	Факс	И-мэйл
Оршин суугчийн баталгаа (Заасан бичиг баримтын аль нэгийг нь хуулбарыг хоёр хувь хавсаргаж, аль төрлийнх болохыг хажууд нь тэмдэглэнэ үү (V))	_ Утасны төлбөрийн нэхэмжлэл _ Банкны дансны хуулга/Зээлийн картын хуулга _ Байрны түрээсийн хүчин төгөлдөр гэрээ _ Оршин суугаа газраа худалдан авсан эсвэл түрээслэсэн тухай гэрээ _ Төр захиргааны байгууллагаас ирүүлсэн, ҮЦТТХТ-өөс хүлээн зөвшөөрөх бусад мэдэгдэл/захидлууд (тодруулна уу)..... \ҮЦТТХТ-ийн данс нээлгэх маягыг бөглөж өгсөн өдрөөс хойш гурван сарын дотор ирүүлнэ.\				
Оршин суугаа газрын байдал	- Өөрийн өмч -Лизинг/Түрээс -Найзынх/Хамаатных, -Эцэг эхийнх, -Албаны, -Дотуур/Түр амьдрах байр, - Бусад газар – Тодруулна уу.....				
Харилцагч эсвэл түүний гэр бүлийн гишүүн нь Улс төрийн идэвхтэн мөн үү? Тийм Үгүй					
Хэрэв "Тийм" бол тодруулна уу:					

Ажил эрхлэлт

Ажилтнууд	a) Мэргэжил	
	b) Байгууллагын нэр	
	c) Байгууллагын хаяг	
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг/ Мэргэжилтнүүд	a) Бизнесийн чиглэл/ ажил мэргэжил	
	b) Бүртгүүлсэн хаяг	

Бусад дэлгэрэнгүй мэдээлэл

Жилд хийх хэлцлийн дүнгийн багцаа: Тэмдэглэнэ үү (V)	<input type="checkbox"/> 1,000,000 төгрөгөөс (1.0 сая) бага <input type="checkbox"/> 10.0 – 50.0 сая төгрөг	<input type="checkbox"/> 1.0 – 5.0 сая төгрөг <input type="checkbox"/> 50.0–100.0 сая төгрөг	<input type="checkbox"/> 5.0 – 10.0 сая төгрөг <input type="checkbox"/> 100.0 сая төгрөгөөс их
Санхүүжилтийн эх үүсвэр	__Борлуулалт, бизнесийн орлого __Гэрээний орлого __Хөрөнгө оруулалтын орлого/ Хадгаламж __Өмч/Хөрөнгийн Борлуулалт __Бэлэг __Гишүүнчлэлийн орлого __Шимтгэлийн Орлого __Гэр бүлийн мөнгөн гуйвуулга __Экспортын орлого __Цалингийн орлого __Хандив/Буяны ажиллагаа (Дотоод/Гадаад) __Бусад (Тодруулна уу).....		
Бусад холбогдох бизнес / мэргэжлийн үйл ажиллагаа, бизнесийн ашиг сонирхол			
Бусад дэлгэрэнгүй мэдээлэл Тэмдэглэл: (Хэрэв байгаа бол)			

Банкны дансны дэлгэрэнгүй мэдээлэл

Банк	Салбар	Дансны дугаар	Дансны төрөл

Төлбөр гүйцэтгэх заавар

<input type="checkbox"/>	Үнэт цаас борлуулсны орлогыг ирээдүйн төлбөрт хадгалж үлдээх
<input type="checkbox"/>	Худалдах/ худалдан авах ажиллагаа тусдаа байх

ХАРИЛЦАГЧИЙН МЭДҮҮЛЭГ

1. Би/бид энэхүү өргөдөлд өгсөн мэдээлэл нь үнэн, зөв болохыг мэдэгдэж байна.
2. Би/Бид “үйлчилгээний нөхцлүүд” болон [Брокер]-оор гүйцэтгүүлэх Үнэт цаасны гүйлгээтэй холбогдох МХБ-ийн журамтай (цаашид өөрчлөгдөж болно) танилцаж, сайтар ойлгосон гэдгээ мэдэгдэж байна. Дээр дурьдсан үйлчилгээний нөхцлүүдийг дагаж мөрдөхөө би/бид зөвшөөрч байна.
3. Үнэт цаасны хэлцлийг (төлбөр нь төлөгдөөгүй хэлцлийг зохицуулах дүрэм журам г.м) зохицуулахтай холбоотой МХБ-ээс гаргасан дүрэм журмуудтай (цаашид өөрчлөгдөж болно) танилцаж, ойлгосон болохоо би/бид мэдэгдэж байна.
4. Би/бид худалдаж авсан үнэт цаасны төлбөрийг Т+3 буюу төлбөр тооцоо хийгдэх өдрөөс өмнө [Брокер]-ийн дансанд байршуулахаа мэдэгдэж байна. Хэрэв төлбөрөө хугацаанд нь байршуулж чадаагүй тохиолдолд, төлбөр тооцоо хийгдэх ёстой байсан өдрөөс төлбөр төлөгдөх өдөр хүртэлх хугацаанд хүүгийн торгууль (торгууль ногдуулах хамгийн дээд хувь ...) төлөхөө зөвшөөрч байна. Худалдан авсан үнэт цаасны төлбөрийг хугацаанд нь гүйцэтгэж чадаагүй тохиолдолд, төлбөр нь хийгдээгүй үнэт цаас болон ҮЦТТХТ дэх миний/бидний дансан дахь төлбөр нь бүрэн төлөгдсөн аливаа үнэт цаасыг арилжиж, [Брокер]-т төлөх

ёстой бүх төлбөрийг /худалдан авсан үнэт цаасны төлбөр, торгууль, хураамж г.м/ барагдуулах эрхийг [Брокер]-г олгож буйгаа хүлээн зөвшөөрч байна. Миний/бидний ҮЦТТХТ дансанд буй үнэт цаасыг захиран зарцуулах эрхийг үүгээр [Брокер]-г олгож буйгаа би/бид ойлгож, зөвшөөрч байна.

5. Би/Бид [Брокер]-г төлбөрийн өртэй байгаа тохиолдолд эсвэл уг өргөдлийн “төлбөр гүйцэтгэх заавар” хэсэгт зааснаар ирээдүйн худалдан авалтын төлбөрт миний/бидний үнэт цаас борлуулсны орлогыг хадгалахыг Би/Бид зөвшөөрч байна.

- [Брокер] нь надад/ бидэнд төлөх, надаар/ биднээр төлүүлэх төлбөрийн аль алинд нь эхэнд орсныг эхэлж зарлагдах төлбөрийн зарчмыг баримтална.
- [Брокер] нь миний/бидний дансанд тохируулах бичилт хийж, сар тус бүрийн эцэст төлбөр нь хүлээгдэж буй хэлцлүүдийг тодруулан дансны хуулгыг илгээнэ.

6. [Брокер] нь миний/бидний нэрийн өмнөөс (үнэт цаас худалдах/ худалдан авах зуучлагчийн үүргийн дагуу, эсвэл хувьцаанд хамаарах ногдол ашиг, үнэт цаас тэргүүн ээлжинд худалдан авах эрх, бонус болон бусад урамшуулалтай холбоотойгоор) гүйцэтгэсэн шууд/шууд бус гүйлгээтэй холбоотойгоор аливаа хохирол, алдагдал хүлээсэн тохиолдолд Би/Бид түүнийг хариуцаж, үүссэн алдагдал, хохирлоос [Брокер]-ийг чөлөөлнө гэдгээ үүгээр хүлээн зөвшөөрч байна.

7. ЭРСДЭЛ ХҮЛЭЭХ МЭДЭГДЭЛ: Үнэт цаасны ханш тогтмол хэлбэлздэг бөгөөд заримдаа маш огцом өөрчлөгддөг. Үнэт цаасны ханш нь өсөх, буурах аль ч чигт өөрчлөгдөж болзошгүй бөгөөд бүр үнэгүйдэх ч магадлалтай. Үнэт цаасыг худалдан авч, худалдсаны дүнд ашиг олох, алдагдал хүлээх магадлалтайг Би/Бид ойлгож байна.

[Брокер] нь дээрх бүх мэдэгдлүүд, түүний дотор ЭРСДЭЛ ХҮЛЭЭХ МЭДЭГДЛИЙГ надад/бидэнд тайлбарлаж ойлгуулсан бөгөөд Би/Бид уг нөхцлүүдийг уншиж, сайтар ойлгосон болохоо мэдэгдэж байна.

[Брокер] нь үнэт цаасны арилжаанд оролцох эрх бүхий мэргэжлийн байгууллага бөгөөд үнэт цаасны арилжааны холбогдолтой асуудлаар [Брокер] болон түүний төлөөлөгчтэй байнгын холбоотой ажиллах нь данс эзэмшигчийн өөрийнх нь үүрэг болохыг ойлгож байна.

I НЭР: Гарын үсэг:

II НЭР: Гарын үсэг:

III НЭР: Гарын үсэг:

Огноо:

Гэрч: Нэр: Нэр:

Хаяг:..... Хаяг:.....

Гарын үсэг:..... Гарын үсэг:.....

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД	Холбогдох бүх бичиг баримтуудыг хавсаргасан	Хөрөнгө оруулалтын зөвлөх		Гарын үсэг		Огноо	
	ТИЙМ/ҮГҮЙ	Системд оруулсан		Гарын үсэг		Огноо	

Дараах баримт бичгийг хавсаргана уу:

1. Иргэний үнэмлэхийн хуулбар – 2 хувь
2. Хэрэглээний төлбөрийн /аль нэг/ сүүлийн үеийн нэхэмжлэл (цахилгаан, ус, утасны төлбөрийн нэхэмжлэл гэх мэт), банкны дансны хуулга болон адилтгах бусад баримт (сүүлийн 3 сарын) – 2 хувь
3. Дансны дэлгэрэнгүй мэдээлэл, баталгаа (байнгын оршин суугч биш бол)

---oOo---